



**НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 06 сарын 16 өдөр

Дугаар A/83


Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7, 49 дүгээр зүйлийн 49.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Эрүүл мэндийн төвийн эмч, ажиллагсдын тасралтгүй сургалтын журмыг хавсралтаар баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Хүний нөөцийн алба, Дарь эх нэгдсэн эмнэлгийн дарга, Зөвлөх поликлиник, Салбар 1,2-р амбулаторийн эрхлэгч нарт тус тус даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт хариуцсан ажилтанд даалгасугай.
4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн төвийн даргын 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн A/63 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



М.БОЛД

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын
20~~22~~ оны 06... дугаар сарын 16.....-ний өдрийн
А.ПЗ....дугаар тушаалын хавсралт



ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭН, АЖИЛТНЫ ТАСРАЛТГҮЙ СУРГАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүл мэндийн төвийн хэмжээнд Захиргаа, Дарь эх нэгдсэн эмнэлэг, Зөвлөх поликлиник, Салбар 1,2-р амбулаторийн эмчилгээ, үйлчилгээний чанар, үр дүнг сайжруулахад өндөр мэдлэг, чадвартай, мэргэжлийн хүний нөөцийг сонгон авах, тэдгээрийн мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, сургалтын явцад хяналт тавьж үр дүнг тооцоход энэхүү журмын зорилго оршино.

Хоёр.Сургалтын ажлыг зохион байгуулах чиглэл

2.1. Эрүүл мэндийн төвийн хэмжээнд мэргэжил олгох сургалтыг Хүний нөөцийн албаны дарга хариуцаж хүний нөөцийн сургах, сургалтын хугацаанд олгох цалин хөлс, сургалтын төлбөрийн асуудлыг Эрүүл мэндийн төвийн даргад танилцуулж төлөвлөлтийг хийнэ.

2.2. Дарь эх нэгдсэн эмнэлэг, Зөвлөх поликлиник, Салбар 1,2-р амбулатори нь Дотоодын тасралтгүй сургалт хариуцсан эмнэлгийн мэргэжилтнийг нэгжээсээ томилон хариуцуулж жил бүрийн эхэнд Сургалтын төлөвлөгөөг Нэгдсэн эмнэлгийн дарга, Амбулаторийн эрхлэгч баталж хуваарийн дагуу сургалтыг явуулна. Улирал бүр нэгжүүдэд хийгдсэн Дотоодын сургалтын материал /хичээлийн удирдамж, ирц, тайлан/-ыг Хүний нөөцийн албаны даргад ирүүлнэ.

2.3. Сургалтын ажлыг тайлагнах

Гурав. Эмнэлгийн мэргэжилтний сургалтын хэрэгцээг тодорхойлох

3.1. Эрүүл мэндийн төвийн ажлын байранд тавигдах шаардлага, энэхүү ажлын байранд ажиллах ажилтны мэргэжлийн ур чадварын зөрүүгээр сургалтын хэрэгцээг тодорхойлно.

3.2. Сургалтын төлөвлөхдөө хүний нөөцийн судалгаа, ажлын байранд тавигдах шаардлага, тухайн ажилтны сургалтанд хамрагдсан байдал, эмчилгээ оношлогооны техник хэрэгсэл ашиглах байдал зэргийг харгалзана.

3.3. Сургалтыг төлөвлөхдөө хаана, ямар сургалтын байгууллагад сургах, дагалдуулан сургах байгууллага дээр сургах хэрэгцээг тодорхойлж, сургалтын төлбөрийг төсвийн холбогдох зардлаас гаргана.

3.4. Ажиллагсдыг 1 сараас 1 жилийн төрөлжсөн мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулна.

3.5. Ажиллагсдыг эзэмшсэн мэргэжлийн дагуу мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх болон магистр, докторын сургалтанд хамруулах, ахлах, тэргүүлэх зэрэг авахад дэмжлэг үзүүлж, цаашид албан тушаал дэвшүүлэх боломжийг олгоно.

3.6. Гадаадын өндөр хөгжилтэй оронд эзэмшсэн мэргэжлээрээ туршлага судлах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Дөрөв. Ажилтнуудыг сургалтанд хамруулах

4.1. Эрүүл мэндийн төвийн эмч, ажилтнууд ажиллах хугацаандаа Эрүүл мэндийн төвийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан хамтын гэрээнд заасны дагуу мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдаж мэргэжлээ байнга дээшлүүлэх ба төрийн сангийн болон байгууллагын зардлаар хийж гүйцэтгэж буй ажил, мэргэжлийнхээ чиглэлээр мэдлэгээ дээшлүүлэх санал гаргавал байгууллага дэмжлэг үзүүлэх чиглэл баримтална.

4.2. Ажилтнуудын мэргэжлийн болон хууль эрх зүй, эдийн засаг, менежмент, гадаад хэл, компьютерийн мэдлэг дээшлүүлэх сургалтанд хамруулах ажлыг байгууллагаас зохион байгуулах

4.3. Байгууллага дээр танин мэдэхүй болон мэргэжил, ур чадвараа дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх ном, гарын авлага бүхий кабинет, номын сан, үзүүлэн таниулах материал, техник хэрэгслээр хангаж тохижуулсан байна.

4.4. Эмчилгээ, оношлогооны шинэ техник хэрэгсэл ашиглах, эмчилгээний шинэ арга технологи нэвтрүүлэхэд эмч, ажилтнуудыг урьдчилан бэлтгэх бодлого барьж ажлын нөхцөл байдлаас шалтгаалж шаардлагатай бол гадаад, дотоодын эрүүл мэндийн байгууллагад туршлага судлуулах, мэргэжлийн сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулна.

4.5. Эрүүл мэндийн төвийн сургалтын бодлогын дагуу мэргэжил дээшлүүлэх, ажлын байрны шаардлагаар шинээр мэргэжил эзэмших сургалтанд ажлаасаа түр

чөлөөлөгдөн хамрагдаж байгаа ажилтанд суралцах хугацаанд Дотоод журам, Хамтын гэрээнд заасны дагуу зохих цалингийн хувийг олгоно.

4.6. Гадаад, дотоодын сургалтанд хамрагдсан эмч, ажиллагсадтай тогтвортой ажиллах гэрээ байгуулж, гэрээнд заасан үүрэг хариуцлагыг нарийн тооцдог тооцож, гэрээнд сургалтанд хамрагдсан ажилтны тогтвор суурьшилтай ажиллах хугацааг ажил мэргэжлийн онцлог, сургалтанд хамрагдсан хугацаа, сургалтын зардал зэргээс хамааруулан ялгавартай тогтоож болно.

4.7. Ажилтныг ажил үүрэгт нь холбоотой чиглэлээр ажлын байрнаасаа хөндийрэлгүйгээр богино хугацааны сургалтанд хамруулах тохиолдолд ажлаас түр чөлөөлөхгүйгээр явуулж, ажил үүргээ орхигдуулахгүй байх хариуцлагыг суралцагч хариуцна.

4.8. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургах тасралтгүй дотоодын сургалт зохион байгуулах төлөвлөгөөний дагуу тухайн нэгжийн сургалт хариуцсан эмч, ажилтан сургалтыг зохион байгуулж явуулна. Нэгжийн сургалт хариуцсан эмч сургалтын ирц, тайлан, хичээл, бусад холбогдох материалуудыг баримтжуулж ажиллана.

Тав. Сургалтын ажлыг тайлагнах

5.1. Эрүүл мэндийн төвийн эмч, ажиллагсдын тасралтгүй сургалтын үр дүнг хагас, бүтэн жилээр холбогдох тайланд тусгана. Нэгжийн Дотоод сургалт хариуцсан ажилтан Дотоод сургалтын бичмэл тайланг хагас, бүтэн жилээр гаргаж 1 хувийг Хүний нөөцийн албаны даргад ирүүлнэ.

5.2. Сургалтыг чанартай, үр дүнтэй зохион байгуулах, эрэлт хэрэгцээг оновчтой тодорхойлох, сургалтанд хамрагдсан ажилтныг ажил, мэргэжил дээр нь тодорхой ахиц гаргуулах асуудалд нэгжийн дарга нар анхаарлаа хандуулах үүрэг хүлээнэ.

5.3. Сургалтанд хамрагдсан ажилтнуудын тайланг тавиулах, сурч мэдсэнээ хамт олонтойгоо хуваалцах, түгээн дэлгэрүүлэх, мэдээлэх ажлыг зохион байгуулна.